

2019 оны 05 дугаар сарын 28

**БАЯНХОНГОР СУМЫН ДУУРСАХ, ЦАГААНЧУЛУУТ,  
ГЭГЭЭНШАВЬ БАГУУДЫН ГЭРЭЛТҮҮЛГИЙН ЗАСВАР,  
ӨРГӨТГӨЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН  
ШАЛГАРУУЛАХТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Тендер шалгаруулалт: Дуурсах, Цагаанчулут, Гэгээншавь багуудын  
гэрэлтүүлгийн засвар, өргөтгөлийн ажлын гүйцэтгэгчийг сонгон  
шалгаруулах ажил**

Гэрээний нэр, дугаар: **БХАБХСЗДТГ/201901016**

Баянхонгор хот  
2019 он

## Нэг. УНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Баянхонгор сумын Засаг даргын тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “**Баянхонгор сумын Дуурсах, Цагаанчулут, Гэгээншавь багуудын гэрэлтүүлгийн засвар, өргөтгөлийн ажил**”-ыг гүйцэтгэх тухай цахим тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Уг тендер нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50000** төгрөгөөр худалдан авна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Төлбөрийн хийх хэлбэр: **Дансаар тушаана.**

Үнийн саналыг **2019 оны 06 дугаар сарын 06-ний өдрийн 10.00** цагаас өмнө Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын 206 тоотод ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 06 дугаар сарын 06-ний өдрийн 10<sup>30</sup>**-т 105 тоотод нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

*Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын 1 давхар 105 тоот  
Утас: 70444411*

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (а) **Унийн санал, Орлцогч компанийн танилцуулга, Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар**
    - (б) **Чадварын мэдээлэл болон бусад баримт бичиг: /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;**
    - (в) **Ижил төрлийн ажил, үйлчилгээ үзүүлсэн туршлага гэрээ холбогдох тайлангийн хуулбар:**
    - (г) **Шаардлагатай тусгай зөвшөөрөл;**
      - Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах эдгээдийн итгэмжлэл
      - **Харьялагдах банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь Хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх**
      - **Татварын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь Хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх**
    - Гэрээг гүйцэтгэгч удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл**
- 4. Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарыт үндэслэнэ.
  - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарыт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
  - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстай бүх

татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.

- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дунд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дунг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дунг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дунг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<b>ТОӨЗ-НЫХОЛБОГОДОХ ЗААЛТ</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>												
TOӨZ 1.1	<p><b>Төндөрийн баримт бичигт заавал ирүүлэх шаардлагатай бусад материал:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>Энэхүү ТББ дахь жишиг маягтын дагуу гаргаж баталгаажуулсан үнийн санал, техникийн тодорхойлолтод заагдсан барааг гэрээний хугацаанд шуурхай нийлүүлэх тухай тодорхойлолт</li> <li>Төндөрт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд: <ul style="list-style-type: none"> <li>- <b>Өргөгч автоворышка-1ш /Мэргэжлийн хяналтын Улсын байцаагчийн магадлалаар орсон байна.</b> /</li> <li>- <b>Ачааны машин-1ш</b></li> <li>- <b>Гагнуурын апрап</b></li> <li>- <b>Люксметр</b></li> </ul> </li> </ol> <p><b>ЖИЧ:</b> Хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэлтэй байх машин механизмын, хэмжих хэрэгслийн техникийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ. Машин механизмууд нь компанийн өөрийн эзэмшлийнх байна.</p> <ol style="list-style-type: none"> <li>Татварын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь</li> <li>Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>Харилцагч банкны тодорхойлолт: Эх хувиар /Монгол банкны тодорхойлолт байж болно/.</li> <li>Нийгмийн даатгалын байгууллагт шимтгэл төлөгч байх ба шимтгэлийн өргүй тодорхойлолт /эх хувь/ НД-7, НД-8 маягтыг хавсарган ирүүлэх.</li> <li>Шүүхийн байгууллагын сүүлийн 3 жилтэй холбогдох тодорхойлолт эх хувиар.</li> <li>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүчинтэй тодорхойлолт эх хувиар.</li> <li>Сүүлийн 2 жилд хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлуудын жагсаалт түүнтэй холбогдох баримтын хуулбар /гэрээ, ажил хүлээлгэн өгсөн акт/.</li> <li>Ажиллах хүч болон машин техник хэрэгсэл компани ажилтан болон өмч байх. /Маягт НД8-аас тулгах/</li> <li>Ерөнхий инженер нь гэрээнд заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ дүйцэх ажил дээр ажилласан туршлагатай байх хугацаа: <b>5 жил</b></li> </ol> <p><b>Түүнийг нотолсон баримт болох: Инженер техникийн ажилчдын сургууль төгссөн диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбар ирүүлэх.</b> Гэрээг хариуцаж ажилласан туршлагатай байх.</p> <table style="width: 100%; border-collapse: collapse;"> <tr> <td style="width: 33%;">Албан тушаал</td> <td style="width: 33%;">Хүний тоо</td> <td style="width: 33%;">Ажлын</td> </tr> <tr> <td></td> <td></td> <td>туршлаг</td> </tr> <tr> <td></td> <td></td> <td>а</td> </tr> <tr> <td>Ерөнхий инженер</td> <td>1</td> <td>5</td> </tr> </table>	Албан тушаал	Хүний тоо	Ажлын			туршлаг			а	Ерөнхий инженер	1	5
Албан тушаал	Хүний тоо	Ажлын											
		туршлаг											
		а											
Ерөнхий инженер	1	5											

	<table border="1"> <tbody> <tr> <td>Цахилгааны инженер</td><td>2</td><td>3</td></tr> <tr> <td>Хөдөлмөр хамгааллын инженер</td><td>1</td><td>3</td></tr> <tr> <td>Автовышканы жолооч /Операторчны курсд суусан байна/</td><td>1</td><td>3</td></tr> <tr> <td>Цахилгаанчин 4-өөс дээш</td><td>4</td><td>2</td></tr> <tr> <td>Оосорлогч, дохиочин</td><td>1</td><td>1</td></tr> </tbody> </table> <p>Дээрх инженерүүд нь үндсэн ажилтан байх ба бүгд даатгуулсан байна. /Тухайн байгууллагад сүүлийн 2 жил тогтвортой суурьшилтай ажилласан байна. / Үндсэн ажилтанг нотлох нийгдмийн даатгалыг ажилд томилсон тушаалын хамт нотариатаар баталгаажуулсан байна. Мөн нийгмийн даатгалын НД7, НД8-ыг сүүлийн 1 жилээр ирүүлнэ.</p> <p>12. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн буюу 2017, 2018 оны борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 90 хувиас багагүй байна.</p> <p>13. Ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: Сүүлийн 2 жилийн аль нэг жилийн хугацаанд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 90 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй нийлүүлэлтийг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байна. Нийлүүлсэн гэрээ хүлээлгэж өгсөн комиссын актыг хавсаргана.</p> <p>14.</p> <p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Сүүлийн жил /2018/-ийн санхүүгийн тайлан дахь түргэн хөрвөх чадвартай хөрөнгө /мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө, дансны авлагын нийлбэр/-ийн хэмжээ тендерт санал болгож буй үнийн дүнгийн 90 хувиас доошгүй байх ба энэ хэмжээний зээлийн эх үүсвэрийг шууд авах боломжтойг нотлох баримт ирүүлэх</p> <p>15. Тендерт оролцогч тухайн бараа нийлүүлэлтэд шаардлагатай тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Эрчим хүчний 3.2.2</p>	Цахилгааны инженер	2	3	Хөдөлмөр хамгааллын инженер	1	3	Автовышканы жолооч /Операторчны курсд суусан байна/	1	3	Цахилгаанчин 4-өөс дээш	4	2	Оосорлогч, дохиочин	1	1
Цахилгааны инженер	2	3														
Хөдөлмөр хамгааллын инженер	1	3														
Автовышканы жолооч /Операторчны курсд суусан байна/	1	3														
Цахилгаанчин 4-өөс дээш	4	2														
Оосорлогч, дохиочин	1	1														
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Баянхонгор аймаг Баянхонгор сумын ЗДТГ</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: 1 давхар <b>105</b> тоот</p> <p>Огноо: <b>2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 00 минут</b></p>															
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Баянхонгор аймаг Баянхонгор сумын ЗДТГ</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: 1 давхар <b>105</b> тоот</p> <p>Огноо: <b>2019 оны 06 дугаар сарын 06-ний өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 30 минут</b></p>															
ТОӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ</p>															

## Дөрөв.ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дуурсах, Цагаанчулуут, Гэгээншавь багуудын гэрэлтүүлгийн засвар, өргөтгөлийн ажил нь:

№	Бараа болон холбогдох үйлчилгээний нэр	Тодорхойлолт
1	Гэрэлтүүлэгч лед	<p>ДНАТ-250вт чийдэнтэй гэрэлтүүлэгчийг орлох үзүүлэлттэй байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- 6-8 метрийн өндөртэй гэрэлтүүлгийн шонд 50-120Вт-ийн гэрэлтүүлэгч тавихаар тооцоолох</li> <li>- 12 метрийн өндөртэй гэрэлтүүлгийн шонд 120-180 Вт-ийн гэрэлтүүлэгч тавихаар тооцоолох</li> </ul> <p>Техник үзүүлэлт Хувьсах гүйдлээр тэжээгддэг (220±)В; (50±2)Гц Гэрлийн урсгал 9000 лм доошгүй Хамгаалалтын зэрэглэл IP67 Чадал 90Вт-аас дээш Ажиллах хугацаа 50000 цаг түүнээс дээш</p>
2	Шууд татах зориулалттай Бүрээстэй хөнгөн цагаан голтой ган утас (СИП)	<p>Сип1 утас 3*16+1*25мм<sup>2</sup> хөндлөн огтлолтой, ГОСТ 1515069 Сип2 утас 3*25+1*35мм<sup>2</sup> хөндлөн огтлолтой Нугаралтанд тэсвэртэй температур -50 градуст ажиллана.</p>
3	Татагч, баригч бусад СИП утсыг бэхлэх арматурууд	СИП утсыг бэхлэх арматурууд нь ОХУ-д ашиглагддаг арматурууд болон түүнтэй дүйцэхүйц байна.
4	Кабель	Тухайн хөрсөнд тавихад зориулагдсан, хөнгөн цагаан голтой, хуяглагдсан, аль ч улсад үйлдвэрлэгдсэн байж болно. ОХУ-ын АВВБ кабель эсвэл түүнтэй дүйцэх стандарт үзүүлэлттэй байна.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

Дээрхи ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд чанарын баталгаа гаргаж өгнө.

Техникийн тодорхойлолт заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагчид эрхийнхээ тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

Тав. ЗУРАГ

**Зургийн санамж**

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

**Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ**

**Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж**

**Зорилт**

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

- (а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;
- (б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өргтийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

**Ажил-өдрийн хуваарь**

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

- (а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.
- (б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

**Магадлашгүй зардал**

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

*Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт*

оруулахгүй.

Зургаа.ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендериийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгх боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Долоо. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | <b>1.1.</b> Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | <b>2.1.</b> Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | <b>3.1.</b> Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | <b>4.1.</b> Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br><br><b>4.2.</b> Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гол түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.  |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | <b>5.1.</b> Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | <b>6.1.</b> Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |
| <b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b>                    |  |
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>                                    | <b>7.1.</b> Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлууна.<br><br><b>7.2.</b> Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b>                         | <b>8.1.</b> Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.  |
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>                          | <b>9.1.</b> Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.<br><br><b>9.2.</b> Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд   |

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## B. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарын тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарын нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## G. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.  
Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.  
Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дунг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- |  |   |
|--|---|
| <p><b>гарын авлага</b></p> <p><b>18. Гэрээг цуцлах</b></p> <p><b>19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр</b></p> <p><b>20. Гүйцэтгэлээс чөлөөлөх</b></p> | <p>авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.</p> <p>17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүй улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг сутгана.</p> <p>18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.</p> <p>18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:</p> <ul style="list-style-type: none"><li>(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;</li><li>(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;</li><li>(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буутгсан;</li><li>(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;</li><li>(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.</li></ul> <p>18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.</p> <p>19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.</p> <p>19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.</p> <p>20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.</p> |
|--|---|

## Найм. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <b>Дуурсах, Цагаанчулуут, Гэгээншиавь багуудын гэрэлтуулгийн засвар, өргөтгөлийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил/БХАБХСЗДТГ/201901016</b>
<b>ГЕН 2.1</b>	<p>Ажил нь <i>[төвч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]</i>-аас бүрдэнэ.</p> <p>Ажлын талбай нь <b>Баянхонгор сумын Дуурсах, Цагаанчулуут, Гэгээншиавь багуудын нутаг дэвсгэр-д</b> байрших ба хавсралт №1-д зааснаар тодорхойлогдсон болно.</p>
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь: <b>Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн П.Баатар</b>
<b>ГЕН 4.1</b>	<p>Ажил эхлэх өдөр <b>2019 оны 06 дугаар сарын 17</b></p> <p>Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <b>2019 оны 07 дугаар сарын 01</b></p>
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <b>7</b> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа <b>365</b> хоног байна.
<b>ГЕН 13.1</b>	<p>Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <b>0,5%</b>байна.</p> <p>Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <b>10%</b>байна.</p>
<b>ГЕН 19.1</b>	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <b>[0]</b> -иартооцно.

Ес. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

**ЗАХИАЛАГЧ**

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

**ГҮЙЦЭТГЭГЧ**

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

*[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.*

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

**1.** Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

**2.** Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

**3.** Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

**4.** Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай/\_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

**5.** Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;

- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;
- 5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
- 7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзольд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]